



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ОЛГОСОН  
ЗЭЭЛИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН"-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН  
АУДИТЫН КОД: БНА-/2020/-04-ГА

ЖДҮХС-ААС БАЯНХОНГОР АЙМАГТ ХУВААРИЛСАН 1000.0 СЯЯ  
ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТЭЭС 681.0 СЯЯ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ  
ОЛГОЖ, АРИЛЖААНЫ БАНКНЫ ШААРДЛАГА ХАНГААГҮЙГЭЭС  
ИРГЭД 319.0 СЯЯ ТӨГРӨГИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ АВАХ  
БОЛОМЖИЙГ АЛДСАН БАЙНА.

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор **Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер **А.Цээням**

Утас: 70442424 цахим хуудас: [tseenyma@audit.gov.mn](mailto:tseenyma@audit.gov.mn)

Ахлах аудитор **Б.Должмаа**

Утас: 88119345 цахим хуудас: [doljmaab@audit.gov.mn](mailto:doljmaab@audit.gov.mn)

Аудитор **Б.Нарангэрэл**

Утас: 99009293 цахим хуудас: [narangerelb@audit.gov.mn](mailto:narangerelb@audit.gov.mn)

Баянхонгор хот 2020 он



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 4/17

Номгон

Г Тайлан баталгаажуулах тухай Г

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалаар батлагдсан "Эрх шилжүүлэх" тухай тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 12.40 дэх заалтыг үндэслэн **ТУШААХ** нь:

Нэг. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор /Б.Должмаа/, аудитор /Б.Нарангэрэл/ нарт үүрэг болгосугай.

Гурав. Аудитын тайланг аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Баянхонгор аймаг дахь Монгол банкны салбар, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /Б.Должмаа/-д даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Түшаал-2020  
2519150

<b>АГУУЛГА</b>	
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙ	5
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6
<b>БҮЛЭГ 1. ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ДЭД ХОРОО БУСАД САНД ХУГАЦАА ХЭТЭРСЭН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛТЭЙ ЗАРИМ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИД ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛИЙГ ДАВХАРДУУЛАН ОЛГОЖ, ЖУРМЫГ ЗӨРЧСӨН БАЙНА.</b>	<b>9</b>
ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ДЭД ХОРООГ ЖУРМЫН ДАГУУ 8 ХҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮНТЭЙ БАЙГУУЛСАН БАЙНА.	9
ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙГ ХҮЛЭЭН АВАХ ЗАРЫГ ОРОН НУТГИЙН ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ХҮРГЭСЭН БАЙНА.	9
ДЭД ХОРОО БАТЛАГДСАН ЖУРАМ, ХХААХҮЯ-ААС ИРҮҮЛСЭН ЧИГЛЭЛИЙН ДАГУУ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЯВУУЛААГҮЙ БАЙНА.	10
<b>БҮЛЭГ 2. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЗЭЭЛ АВСАН ЗЭЭЛДЭГЧИД ТӨСӨЛД ЗААГДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ, ЗЭЭЛИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.</b>	<b>13</b>
ЖДҮХС-ААС АЙМАГТ ХУВААРИЛСАН 1000.0 САЯ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТЭЭС 681.0 САЯ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ ОЛГОЖ, АРИЛЖААНЫ БАНКНЫ ШААРДЛАГА ХАНГААГҮЙГЭЭС ИРГЭД 319.0 САЯ ТӨГРӨГИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ АВАХ БОЛОМЖИЙГ АЛДСАН БАЙНА.	13
ЖДҮХС-ААС ОЛГОСОН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙГ ЗАРИМ ЗЭЭЛДЭГЧ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН БАЙНА.	16
ОРОН НУТГИЙН ОРЛОГООС ХАС БАНКАНД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАРЬЦАА ДАНСАНД БАЙРШУУЛСАН 75.0 САЯ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТЭЭС СҮҮЛИЙН ЖИЛҮҮДЭД ЗЭЭЛ ОЛГООГҮЙН УЛМААС ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ БУЦААН ТАТЖЭЭ.	24
<b>БҮЛЭГ 3. ЖДҮХС-ААС ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗАРЦУУЛАЛТАД АЙМГИЙН ХХААГ ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.</b>	<b>25</b>
АЙМГИЙН ХХААГ-ЫН ЖДХҮАУ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.	25
ТӨСӨЛД ХАМРАГДСАН ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИД АРИЛЖААНЫ БАНК ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАСАН БОЛОВЧ АЙМГИЙН ХХААГ-ААС ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	26
<b>БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ</b>	<b>27</b>
<b>АУДИТЫН ДҮГНЭЛТ</b>	<b>29</b>
<b>АУДИТЫН ЗӨВЛӨМЖ</b>	<b>30</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЖДХУАУ	Жижиг, дунд, хөнгөн үйлдвэр, ахуй үйлчилгээ
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НД	Нийгмийн даатгал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
СХС	Сум хөгжүүлэх сан

**Хүснэгтийн товъёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ЖДҮХС-аас зээл авахаар санал ирүүлсэн, дэмжигдсэн төслийн судалгаа	5
Хүснэгт 2	Арилжааны банкаар дамжуулан олгосон хөнгөлөлттэй зээлийн судалгаа /сая төгрөгөөр/	6
Хүснэгт 3	Яаманд хүргэсэн болон яамнаас батлагдсан салбарын харьцуулалт	11
Хүснэгт 4	Хөгжлийн бодлогод тусгасан салбарыг харьцуулсан байдал	11
Хүснэгт 5	Арилжааны банкны шаардлага хангасан зээлийн тоо, дүн	13
Хүснэгт 6	Хас банкны дансанд байршуулсан санхүүжилт	23

**Дүрслэлийн товъёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Ирүүлсэн төслийг дэмжигдсэн болон олгосон төсөлтэй харьцуулсан байдал	14
Дүрслэл 2	2014-2019 онуудад ЖДҮХС-аас батлагдсан болон олгосон зээл / сая төгрөгөөр	21
Дүрслэл 3	Ажлын байрны тоо	21
Дүрслэл 4	Ажлын байрны харьцуулалт	22
Дүрслэл 5	НДШ төлөлтийн байдал	22

<b>Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх</b>	<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүй</b> Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын "Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2020 оны А/53 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан аудитын сэдвийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.
<b>Аудитын зорилт</b>	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас арилжааны банкаар дамжуулан 2017-2019 онд олгосон хөнгөлөлттэй зээлийн зарцуулалт, үр дүнд аудит хийж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: <ol style="list-style-type: none"><li>1. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн төслийн сонгон шалгаруулалтыг журмын дагуу явуулсан эсэх?</li><li>2. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүн гарсан эсэх?</li><li>3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан эсэх?</li></ol>
<b>Аудитын хамарсан хүрээ</b>	Аудитад ЖДҮХС-аас арилжааны банкаар дамжуулан 2019 онд олгосон хөнгөлөлттэй зээлийг хамруулан гүйцэтгэлээ.
<b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b>	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, мэдээ тайлан, судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер А.Цээням чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Б.Нарангэрэл нар гүйцэтгэв.

Аудитын нээлтийг 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдөр хийж, зээлдэгчийн зээл ашиглалт, үйл ажиллагааг шалгах ажлыг 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан, тайланг 2020 оны 06 дугаар сарын 29-ны өдөр ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, ХХААГ, Монгол банкны салбарт хүргүүлж ажиллав.

**Хүндрэл бэрхшээл**

- ЖДҮХС-аас арилжааны банкаар дамжуулан зээл авсан зээлдэгч нарын зээлийн зарцуулалтыг шалгахад зээлийн хөрөнгөөр эргэлтийн болон үндсэн хөрөнгө авахдаа нэхэмжлэх, орлого, зарлагын баримт авдаггүйгээс зээлдэгчийн ашиглаж байгаа тоног төхөөрөмжийг хуучин байсан, шинээр авсан эсэхийг тодруулах боломжгүй байв.
- Мөн дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед бизнесийн салбаруудын дийлэнх нь үйл ажиллагаа зогссон байв.

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан/цаашид ЖДҮХС гэх/-аас 2017, 2018 онуудад санхүүжилт олгоогүй ба Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын /цаашид ХХААХҮС гэх/ 2019.02.21-ний өдрийн А/41 дүгээр тушаалаар ЖДҮХС-аас Баянхонгор аймагт 2019 онд 1000.0 сая төгрөг хуваарилсан байна.

Аймгийн Засаг даргын 2019.05.22-ний өдрийн А/280 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын орлогч даргаар ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй аймгийн жижиг дунд үйлдвэрийн /цаашид ЖДҮ гэх/-ийн төслийг сонгон шалгаруулж, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий, хяналт тавих дэд хороог томилж, 2019 онд иргэд, хуулийн этгээдээс нийт 103 төслийг хүлээн авснаас журамд заасан зээлийн доод хэмжээнээс доогуур 3 төслийг хасаж, 2019.07.02-ны өдөр дэд хороогоор 100 төслийг хэлэлцэж, 1 дүгээр эрэмбээр шаардлага хангасан 1000.0 сая төгрөгийн 40 төсөл, 2 дугаар эрэмбээр 180.0 сая төгрөгийн 9 төслийг дэмжин, аймгийн Засаг даргад албан бичиг хүргүүлсэн байна.

Хүснэгт 1. ЖДҮХС-гаас зээл авахаар санал ирүүлсэн, дэмжигдсэн төслийн судалгаа

Ангилал	Ирүүлсэн төсөл	Дэд хорооноос шалгаруулсан төсөл	Банкны шаардлагад нийцэж, санхүүжилт олгосон төсөл
Иргэн	82	34	17
Аж ахуйн нэгж	18	15	8
<b>Нийт</b>	<b>100</b>	<b>49</b>	<b>25</b>

Аймгийн Засаг даргаас 2019.07.22-ны өдөр ЖДҮХС болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкнуудад албан бичиг хүргүүлсэн ба дэд хороогоор дэмжигдсэн 49 төслөөс арилжааны банкнаас тавьсан шаардлагыг хангасан 25 иргэн, аж ахуйн нэгжид нийт 640.0 сая төгрөгийг Хаан, Хас, Төрийн банкаар олгож, ЖДҮХС-аас дэмжигдсэн 1 иргэнд Хаан банк 41.0 сая төгрөгийг олгож, аймагт батлагдсан 1000.0 сая төгрөгийн санхүүжилтээс 681.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, дэд хороогоор дэмжигдсэн 24 төслүүд арилжааны банкны зээлийн

шаардлагыг хангахгүйн улмаас аймагт батлагдсан дүнгээс 319.0 сая төгрөгийн санхүүжилтийг ашиглах боломжийг алдсан байна.

*Хүснэгт 2. Арилжааны банкаар дамжуулан олгосон хөнгөлөлттэй зээлийн судалгаа /сая төгрөгөөр/*

Ангилал	Хас банк		Хаан банк		Төрийн банк		Нийт олгосон	
	Төслийн тоо	Мөнгөн дүн	Төслийн тоо	Мөнгөн дүн	Төслийн тоо	Мөнгөн дүн	Төслийн тоо	Мөнгөн дүн
Иргэн	1	20.0	14	406.0	2	40.0	17	466.0
ААН	2	40.0	7	175.0	0	0	9	215.0
Нийт	3	60.0	21	581.0	2	40.0	26	681.0

Төсөл сонгон шалгаруулах дэд хороо ХХААХҮЯ-аас баталсан салбарын хүрээнд төслийг сонгон шалгаруулсан боловч ХЭДС, СХС-ийн зээлийн мэдээллийг гаргуулж нягтлаагүйгээс эдгээр санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй иргэн, ААН-д 60.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, журмыг зөрчсөн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

ХХААХҮС-ын 2019.05.14-ний өдрийн А/146 дугаар тушаалаар хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөлийг баталсан ба арилжааны банкаар дамжуулан олгох зээлийн хүүг 8 хувиас ихгүй байх, 5 хүртэл жилийн хугацаатай олгож, үндсэн зээлээс эхний 12 сарын хугацаанд чөлөөлөхөөр заасны дагуу Хаан банк 5.4%, Хас банк 5.6%, Төрийн банк 5.8%-ийн хүүтэй, 36-60 сарын хугацаатай олгож, нэг зээлдэгчээс бусад зээлдэгч эхний 12 сарын хугацаанд үндсэн зээлээс чөлөөлөгдсөн байна.

Галуут, Заг, Жаргалант, Хүрээмарал, Баацагаан сумдад үйл ажиллагаа явуулж байгаа 5 зээлдэгчээс бусад 21 зээлдэгчийн үйл ажиллагаатай аудитын явцад шалгахад 14 зээлдэгчийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, орон нутагт импортыг орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна. Харин Төрийн банкны 2, Хаан банкны 4, Хас банкны 1 зээлдэгч төслийн зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үйл ажиллагаа эхлээгүй зөрчил илэрсэнд хугацаатай албан шаардлага хүргүүлж, аймгийн ХХААГ-т хариуцуулав.

Төсөл сонгон шалгаруулах дэд хороонд ирүүлсэн төслийн дүнг бууруулж батлахдаа батлагдсан зээлийн эх үүсвэрийг юунд зарцуулах, хэдэн ажлын байр нэмэгдүүлэх нь тодорхой биш, арилжааны банктай байгуулсан зээлийн гэрээнд зээлийн зориулалтыг дэлгэрэнгүй тусгаагүй зэргээс шалтгаалж иргэн, ААН хөнгөлөлттэй зээлийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж хөнгөлөлттэй зээлийн зарцуулалтыг анхан шатны баримтаар баталгаажуулаагүйгээс зээлийг юунд зарцуулсныг нотлох боломжгүй байна.

Төсөл хэрэгжүүлэгч иргэн, ААН хадгалсан болон шинээр бий болсон ажлын байранд ажиллаж байгаа иргэдийг нийгмийн даатгалд хамруулаагүйгээс бодит ажлын байрны тоог нотлох боломжгүй байгаа ба зээлдэгч нарын өгсөн мэдээллээр 82 ажлын байр хадгалж, шинээр 44 ажлын байрыг бий болгосон дүнтэй байна.

Аймгийн Төрийн аудитын газраас 2017 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээлийн дэлгэрэнгүй мэдээ, судалгааг хугацаанд нь

гаргаж хүргүүлэх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, хадгалсан болон шинээр нэмэгдсэн ажлын байрны тоог бодит тоонд үндэслэн гаргаж хүргүүлээгүй байна.

Арилжааны банкууд зээлдэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахдаа зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй зээлдэгчдэд тухай бүр арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Аймгийн ХХААГ-ын ЖДХҮАҮ хариуцсан мэргэжилтэн 2019 онд ЖДҮХС-аас олгосон зээлд хамрагдсан иргэн, ААН-ийн зээл ашиглалт, ажлын байр нэмэгдүүлсэн байдалд хяналт тавьж ажиллаагүй, ХХААХҮЯ-д хүргүүлсэн тайланг зөрүүтэй гаргасан, шалгараагүй буцаагдсан төслийн шалтгааныг журмын дагуу дэлгэрэнгүй бүртгэж баталгаажуулаагүй, дэд хорооны хурлын тэмдэглэлийг дэлгэрэнгүй хөтлөөгүй, бусад сангаас зээл авсан иргэн, ААН-ын судалгааг авч сонгон шалгаруулалтад ашиглаагүй зэргээр ажилд хариуцлагагүй хандсан байгаа тул тус албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн ХХААГ-ын даргад хүргүүлэв.

**БҮЛЭГ 1. ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ДЭД ХОРОО БУСАД САНД ХУГАЦАА ХЭТЭРСЭН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛТЭЙ ЗАРИМ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИД ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛИЙГ ДАВХАРДУУЛАН ОЛГОЖ, ЖУРМЫГ ЗӨРЧСӨН БАЙНА.**

**ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ДЭД ХОРООГ ЖУРМЫН ДАГУУ 8 ХҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮНТЭЙ БАЙГУУЛСАН БАЙНА.**

1.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-119 дүгээр тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын /цаашид журам гэх/ 6.8<sup>1</sup>-т заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын 2019.05.22-ний өдрийн А/280 дугаар захирамжаар аймгийн жижиг дунд үйлдвэрийн /цаашид ЖДҮ гэх/-ийн төслийг сонгон шалгаруулж, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий, хяналт тавих дэд хороог томилсон байна.

1.2. Журмын 6.1<sup>2</sup>, 6.2<sup>3</sup>-т заасны дагуу дэд хороог 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, даргаар нь аймгийн Засаг даргын орлогч дарга, нарийн бичгээр нь аймгийн ХХААГ-ын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, гишүүдээр аймгийн ХХААГ-ын дарга, аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга нарыг томилсон ба журмын 6.3<sup>4</sup>-т заасны дагуу дэд хорооны бүрэлдэхүүнд Хуульчдын холбооны гишүүн өмгөөлөгч, Баянхонгор аймаг дахь Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны дарга, Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга, Хүнсчдийн холбооны тэргүүлэгч нарыг томилжээ.

**ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙГ ХҮЛЭЭН АВАХ ЗАРЫГ ОРОН НУТГИЙН ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ХҮРГЭСЭН БАЙНА.**

1.3. Төсөл хүлээн авах зарыг “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 10.4<sup>5</sup>, ХХААХҮЯ-ны 2019.05.16-ны өдрийн 01/1930 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 2019.05.17-ний өдрөөс эхлэн орон нутгийн “Баянхонгор Телевиз”-ээр 16 хоног, “ТВ-10” телевизээр 8 хоног иргэд, олон нийтэд нээлттэй явуулсан байгаа нь нэхэмжлэл, зараар нотлогдож байна.

1.4. Орон нутгийн “Баянхонгор Телевиз”, “ТВ-10” телевизээр мэдээлсэн төсөл хүлээн авах зард “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай,

<sup>1</sup> Хорооны бүрэлдэхүүнийг Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, дэд хорооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга тус тус батална.

<sup>2</sup> Хороо, дэд хороо нь дарга, гишүүд, нарийн бичгийн даргаас бүрдсэн найман хүний бүрэлдэхүүнтэй байна.

<sup>3</sup> Дэд хорооны бүрэлдэхүүнд аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагын дарга болон аймгийн хөдөлмөр, халамжийн хэлтсийн төлөөлөл орох бөгөөд нарийн бичгийн даргаар аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн /цаашид аймгийн мэргэжилтэн гэх/ байна.

<sup>4</sup> Хороо, дэд хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын 4 төлөөлөл байна.

<sup>5</sup> Сан, аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь төсөл хүлээн авахаас хуанлийн 10-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлана. Төслийг хуанлийн 14 хоногийн турш хүлээн авна.

хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам"-ын 10.1<sup>6</sup>-т заасан төсөл авч эхлэх хугацаа, дуусах хугацаа, байршил, зээлийн нөхцөлийг бүрэн мэдээлсэн ч харин аймагт төсөл хүлээн авахтай холбоотой мэдээллийг авах утасны дугаарыг тодорхой бичээгүй, Улаанбаатар хотод төсөл авах утасны дугаарыг дэлгэрэнгүй оруулсан байна.

#### **ДЭД ХОРОО БАТЛАГДСАН ЖУРАМ, ХХААХҮЯ-ААС ИРҮҮЛСЭН ЧИГЛЭЛИЙН ДАГУУ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЯВУУЛААГҮЙ БАЙНА.**

1.5. ХХААХҮ-ийн сайдын 2019.05.14-ний өдрийн А-146 дугаар тушаалаар орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих 14 салбарыг баталсан ба дэд хороо ЖДҮ-ийг хөгжүүлэх төслийн зээлийг сонгон шалгаруулахдаа тус чиглэлийг баримталж ажилласан байна.

1.6. Гэвч журмын 1.4.2<sup>7</sup>, 1.4.4<sup>8</sup> болон ХХААХҮЯ-ны 2019.05.31-ны өдрийн 01/2141 дугаар албан бичгээр аймгийн ХХААГ-ын даргад ирүүлсэн чиглэлийн 2<sup>9</sup>-т заасныг зөрчиж, зөвхөн Мал хамгаалах сангаас зээлдэгчийн жагсаалтыг гаргуулан авч, харин Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон аймгийн ХХҮГ-аар дамжуулан олгож байгаа ХЭДС-ийн зээл, сумын Засаг даргын захирамжаар олгож байгаа СХС-ийн зээлийн судалгааг авч, тухайн иргэн, аж ахуйн нэгж зээлтэй эсэхийг нягталж шалгалгүйгээр төслийг сонгон шалгаруулсан байна.

1.7. Аймгийн ХХААГ-т сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн ажиллаж, сумдын СХС-ийн зээлдэгч нарын мэдээлэл программаас гарах бүрэн боломжтой байхад түүнийг ашиглаагүйгээс СХС-ийн зээлийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй дараах иргэн, аж ахуйн нэгжид ЖДҮХС-ийн зээл олгосон зөрчил илэрлээ.

#### **Аудитын илрүүлэлт**

1. "Буянт нар уул" ХХК нь хуурай болон чихэртэй аарцаар бүтээгдэхүүн хийх, үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар Заг сумын сум хөгжүүлэх сангаас 2017.05.12-ны өдөр 10.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, 7.9 сая төгрөгийн муу зээлийн үлдэгдэлтэй байхад ЖДҮХС-аас үрлэн чихрийн үйлдвэрлэл эрхлэхээр 2019.09.06-ны өдөр 20.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон;
2. Иргэн Б.Жавзандулам нь Галуут сумын сум хөгжүүлэх сангаас 2017.02.20-ны өдөр 7.0 сая төгрөгийн зээл авч, 8.2 сая төгрөгийн муу зээлийн үлдэгдэлтэй байхад ЖДҮХС-аас зээл олгох шийдвэр гарч, 2020.01.06-ны өдөр 41.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Иймд сумдын сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг Монгол банкны мэдээллийн санд оруулах арга хэмжээг авч ажиллахыг аймгийн ХХААГ-т даалгаж, журмын 16 дугаар зүйлд заасны дагуу хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй дээрх зээлдэгч нарын СХС-аас авсан хөнгөлөлттэй зээлийг санд нөхөн төлүүлэх 16.3 сая төгрөгийн төлбөрийн актыг тогтоов.

<sup>6</sup> Сан нь улсын хэмжээнд төсөл хүлээн авах зарыг өдөр тутмын мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээнэ. Аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь энэхүү зарыг тухайн орон нутагт мэдээлэх үүргийг хүлээнэ. Төсөл хүлээн авах зард төсөл хүлээн авч эхлэх, дуусах хугацаа, байршил, зээлийн нөхцөл, холбоо барих утасны дугаар зэрэг мэдээллийг тусгасан байна.

<sup>7</sup> Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.6, 5.4.8, 5.4.14, 5.4.18-д заасан сангуудад болон сум хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй;

<sup>8</sup> 1.4.4. Монгол банкны зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй, зээлийн муу түүхтэй тохиолдолд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэлтийн төслийг хүлээн авахгүй;

<sup>9</sup> Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Сум хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй, Монгол банкны зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулахгүй байх

1.8. Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас авсан судалгаагаар ХЭДС-аас зээл авсан аж ахуйн нэгжид ЖДҮХС-ийн зээлийг давхардуулж олгосон зөрчил илэрлээ.

#### **Аудитын илрүүлэлт**

*“Ширээ хайрхны нуруу” ХХК нь ХЭДС-аас 2017.06.27-ны өдөр 3.0 сая төгрөгийн зээл авч, 2019.06.27-ны өдөр дуусах гэрээ байгуулсан атлаа зээлийг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн байхад төсөл сонгон шалгаруулах дэд хороо журмын 1.4.2<sup>10</sup> дахь заалтыг зөрчиж, ЖДҮХС-аас 20.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байгаа тул ХЭДС-ийн зээлийн үлдэгдлийг санд буцаан төлүүлэх төлбөрийн актыг тогтоож, аймгийн ХХААГ-т харууцуулав.*

1.9. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар аймгийн ЖДҮ-ийг хөгжүүлэх зорилгоор “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-аар дамжуулан хүүгүй, 3 жилийн хугацаатай олгосон зээлийн үлдэгдлийн судалгааг авч, ЖДҮХС-аас зээл авсан иргэн, ААН-тэй тулгахад дараах зөрчил илэрлээ.

#### **Аудитын илрүүлэлт**

*1. ЖДҮХС-д иштэй тарган зайрмаг төслөөр 25.0 сая төгрөгийн төсөл бичиж, 20.0 сая төгрөгийн зээл авсан иргэн Я.Чагнаадорж нь “Мазаахай” тараг үйлдвэрлэх цех төслөөр 18.0 сая төгрөгийн зээл хүсэж, 2019.07.07-нд 15.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан ба тус иргэний бичсэн төслүүдэд зээлийн хөрөнгөөр хөргүүртэй ачааны машин авахаар заасан байгаа тул “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-аас анх авсан 15.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг буцаан төлүүлэх төлбөрийн актыг тогтоож, аймгийн ХХААГ-т хүргүүлэв.*

1.10. Орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, нэмүү өртөг шингэсэн, олон улсын чанар, стандартын шаардлага хангасан, өрсөлдөх чадвартай зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр, гадаад, дотоод худалдааны эргэлт, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолоор “Үйлдвэржилт 21:100” (2018-2021) үндэсний хөтөлбөрийг баталсан ба аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан ЖДҮХС-аас зээл олгох салбарыг тодорхойлжээ.

1.11. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд Баянхонгор аймагт савхин гутал, оёдол, өндөр даралтын тоосго үйлдвэрлэх, хуурай сүү, чулууны үйлдвэр зэрэг 5 үйлдвэрийг байгуулахаар баталжээ.

1.12. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд болон үйлдвэрлэл хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлогын хүрээнд “Үйлдвэржилт 21:100” (2018-2021) үндэсний хөтөлбөр болон орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан 9 салбарын жагсаалтыг эрэмбэлэн ХХААЯ-нд хүргүүлсэн гэх боловч зөвхөн оёдлын үйлдвэрийг хөгжүүлэх саналыг ХХААХҮЯ-д Баянхонгор аймгийн Засаг даргын 2019.03.21-ны өдрийн 1а/168 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

<sup>10</sup> Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.6, 5.4.8, 5.4.14, 5.4.18-д заасан сангуудад болон сум хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй;

Хүснэгт 3. Яаманд хүрээсэн болон яамнаас батлагдсан салбар

№	Үйл ажиллагааны чиглэл	Аймгаас санал хүргүүлсэн салбар	Яамнаас баталсан салбар
1	Сүү, сүүн бүтээгдэхүүн		
2	Ноос, ноолуур боловсруулах		
3	Арьс, шир боловсруулах		
4	Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэх		
5	Барилгын материалын үйлдвэрлэл		
6	Чулууны үйлдвэр		
7	Мөд боловсруулах үйлдвэр		
8	Мал амьтны тэжээлийн үйлдвэр		
9	Хог, хаягдал дахин боловсруулах үйлдвэр		
10	Мах, махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах		
11	Сав, баглаа, боодол үйлдвэрлэх		
12	Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулах		
13	Туслах аж ахуй		
14	Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх		
15	Бусад		

1.13. ХХААХҮ-ийн сайдын 2019.05.14-ний өдрийн А-146 дугаар тушаалаар орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих нийт 14 салбарыг баталсан ба үүнд аймгаас хүргүүлсэн саналаас чулууны үйлдвэрийг хөгжүүлэх санал хасагдаж, бусад салбарууд дэмжигдсэн байна.

1.14. Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлогод “Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, аялал жуулчлалыг хослуулан кластер-хонгор нутгийн ирээдүй” зорилт дэвшүүлж, 6 салбарыг хөгжүүлэх замаар мах, сүү,

ноос ноолуурын үйлдвэрлэлийн голлох бүс нутгуудын мал сүргийг үйлдвэрлэлийн чиглэлээр нь бүсчлэн хөгжүүлж мал аж ахуйн түүхий эд бүтээгдэхүүнийг бэлтгэх, боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 4 салбарыг хөгжүүлэх талаар тусгасан байна.

Хүснэгт 4. Хөгжлийн бодлогод тусгасан салбарыг харьцуулсан байдал

Салбар	Үйлдвэржилт 21:100 Үндэсний хөтөлбөр	Аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлогод тусгасан салбар	Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	ХХААХҮ-нд хүргүүлсэн салбар
Савхин гутлын үйлдвэр	2020			
Оёдлын үйлдвэр	2020			Тийм
Өндөр даралтын тоосго үйлдвэрлэх үйлдвэр	2019			
Хуурай сүүний үйлдвэр	2018	2016-2025		
Чулууны үйлдвэр	2019			Тийм
Ноос, ноолуур		2016-2025	2016-2020	тийм
Махны үйлдвэр		2016-2025	2016-2020	
Хүнсний ногооны үйлдвэрлэл		2016-2025	2016-2020	
Сүүний үйлдвэрлэл		2016-2025	2016-2020	тийм
Арьс шир боловсруулах үйлдвэр		2016-2025		тийм

Эх сурвалж: Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр, аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, ХХААХҮ-ны албан бичиг

**БҮЛЭГ 2. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЗЭЭЛ АВСАН ЗЭЭЛДЭГЧИД ТӨСӨЛД ЗААГДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ, ЗЭЭЛИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.**

ЖДҮХС-ААС АЙМАГТ ХУВААРИЛСАН 1000.0 СЯ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТЭЭС 681.0 СЯ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ ОЛГОЖ, АРИЛЖААНЫ БАНКНЫ ШААРДЛАГА ХАНГААГҮЙГЭЭС ИРГЭД 319.0 СЯ ТӨГРӨГИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ АВАХ БОЛОМЖИЙГ АЛДСАН БАЙНА.

1.15. Аймгийн ХХААГ журамд заасан хугацаанд 16 сумын 87 иргэн, 16 аж ахуйн нэгжийн нийт 8.3 тэрбум төгрөгийн 103 төсөл хүлээн авсан ба журмын 3.2<sup>11</sup>-т заасны дагуу 20.0 сая төгрөгөөс бага дүнтэй зээл хүссэн 3 иргэний төслийг буцааж, нийт 100 төсөл хүлээн авч, төсөл бүртгэх <http://office.smefund.gov.mn> бүртгэлийн нэгдсэн санд оруулсан байна.

1.16. Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан дэд хороо 2019.06.15-ны өдөр дэд хорооны гишүүдийн 87.5 хувийн ирцтэйгээр хуралдаж, зээл хүссэн 100 төслийн иж бүрдлийг шалгах хуудсаар шалгаж, 51 төслийн шаардлага хангахгүй гэж үзэн буцаасан байна. Тус хурлаар ХХААХҮ-ийн сайдын 2019.05.14-ний өдрийн А-146 дугаар тушаалаар баталсан салбарын жагсаалтад ороогүй нийтийн хоолны газар, тээвэр үйлчилгээ, дулаан үйлдвэрлэл, эрүүл мэндийн үйлчилгээний төслийг дэмжих боломжгүй гэж шийдвэрлэсэн байна. Төслийн шаардлага хангаагүй буцаагдсан иргэн, аж ахуйн нэгжид аймгийн ХХААГ-ын 2019.07.06-ны өдрийн 1/217 дугаар албан бичгээр хариу хүргүүлж, төслийг буцаан олгосон байна.

1.17. Дэд хорооны хурлын тэмдэглэлд зээлдэгч бүрийн төслийг хэлэлцсэн талаар бичигдээгүй, журмын 1.4-т төслийг хүлээн авахгүй байх 11 заалтаас аль заалтыг үндэслэж, төслийг буцаасан талаар мэдээлэл байхгүй байна. Энэ талаар аймгийн ХХААГ-ын ЖДХҮАҮ хариуцсан мэргэжилтнээс тодруулахад ХХААХҮЯ-ны төсөл бүртгэх программд буцаасан шалтгааныг оруулсан, түүнийг одоо хэвлэж авах боломжгүй байна гэсэн тайлбарыг өгсөн болно. Иймд цаашид төсөл сонгон шалгаруулах дэд хорооноос журмын 1.4-т заасан ямар заалтаар төсөл буцаагдсан шалтгааныг дэлгэрэнгүй бүртгэж, баримтжуулж байхыг аймгийн ХХААГ-ын дарга, ЖДХҮАҮ хариуцсан мэргэжилтэн нарт зөвлөв.

1.18. Дэд хороо 2019.07.02-ны өдөр 75 хувийн ирцтэйгээр хуралдаж, 2963.7 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 15 аж ахуйн нэгж, 34 иргэний төслийг хэлэлцэж, ЖДҮХС-аас батлагдсан 1000.0 сая төгрөгийн эх үүсвэрт багтаан тэргүүн ээлжид санхүүжүүлэх 40 төслийг сонгон шалгаруулж, журмын 12.4<sup>12</sup>-т заасны дагуу арилжааны банкны шалгуур үзүүлэлт хангаагүй, барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй зэрэг шалтгааны улмаас эх үүсвэр үлдсэн тохиолдолд санхүүжүүлэх 2 дугаар эрэмбийн 180.0 сая төгрөгийн 9 төслийг шалгаруулсан байна.

<sup>11</sup> Банкаар дамжуулан зээл олгох тохиолдолд Хорооны хурлаар нэг төслийг санхүүжүүлэх доод хэмжээ 300,000,000 /гурван зуун сая/ төгрөг, дээд хэмжээ 1,000,000,000 /нэг тэрбум/төгрөг хүртэл, Дэд хорооны хурлаар нэг төслийг санхүүжүүлэх доод хэмжээ 20,000,000/ хорин сая/ төгрөг, дээд хэмжээ 200,000,000 /хоёр зуун сая/ төгрөг хүртэл байна.

<sup>12</sup> Банкны шалгуур үзүүлэлт хангаагүй, барьцаа хөрөнгө хүрэлцээгүй зэрэг шалтгааны улмаас эх үүсвэр үлдсэн тохиолдолд санхүүжүүлэх төслүүдийн жагсаалтыг тухайн аймгийн хөгжлийн бодлоготой уялдуулан батална.

1.19. Төсөл сонгон шалгаруулах дэд хорооны дарга бөгөөд аймгийн Засаг даргын орлогч нь журмын 12.5<sup>13</sup>-т заасны дагуу шалгаруулсан 49 төслийн жагсаалтыг 2019.07.07-ны өдрийн 16/539 дүгээр албан бичгээр аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн байна.

1.20. Аймгийн Засаг дарга журмын 14.3.3<sup>14</sup> дахь заалтыг хэрэгжүүлж, 2019.07.22-ны өдөр төслийн жагсаалт батлах тухай А/385 дугаар захирамж гаргаж, шаардлага хангасан төслийг сангаас санхүүжүүлэх, хяналт тавьж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосон байна.

1.21. ХХААХҮЯ нь арилжааны банктай гэрээ байгуулах хүртэл зээлийг олгохгүй байх чиглэлийг өгсний улмаас 2019 оны 08 дугаар сараас эхлэн зээл судлагдаж эхэлсэн ба аймгийн ХХААГ-аас арилжааны банкнуудад тухай бүр нь зээл олгох тухай албан бичиг хүргүүлж ажилласан байна.

1.22. Зээл олгохоор дэмжигдсэн иргэн, аж ахуйн нэгж зээл авах арилжааны банкийг өөрөө сонгосон бөгөөд нийт зээлдэгчийн 57.5 хувь нь Хаан банкийг, 30 хувь нь Хас банкийг, 13 хувь нь Төрийн банкийг сонгосон байна. Арилжааны банкаар дамжуулан олгосон нийт зээлийн 80 хувийг Хаан банк олгосон байгаа нь салбарын хэмжээнд зээлийг судалж, олгосонтой холбоотой байна. Харин Хас банк, Төрийн банк нь төв банкныхаа зээлийн хорооноос ЖДҮХС-ийн зээл олгох шийдвэр гарч олгосон байна.

Хүснэгт 5. Арилжааны банкны шаардлага хангасан зээлийн тоо, дүн

№	Банкны нэр	1-р эрэмбээр батлагдаж, банканд хүргүүлсэн төслийн		2-р эрэмбээр батлагдаж, банканд хүргүүлсэн төслийн		Олгосон зээл	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хаан банк	23	610	6	120	20	540
2	Төрийн банк	5	105	2	40	2	40
3	Хас банк	12	285	1	20	3	60
	<b>ДҮН</b>	<b>40</b>	<b>1000</b>	<b>9</b>	<b>180</b>	<b>25</b>	<b>640</b>

Эх сурвалж: Дэд хороогоор дэмжигдсэн төслийн жагсаалт, аймгийн ХХААГ-ын судалгаа

1.23. Дэд хороогоор дэмжигдсэн дээрх зээлээс гадна сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхэлдэг Б.Жавзандулам нь ХХААХҮЯ-ны ЖДҮХС-д 70.0 сая төгрөгийн төсөл бичиж хүргүүлсэн бөгөөд ЖДҮХС-ийн захирлын 2019.08.01-ний өдрийн 1/1091 дүгээр албан бичгээр орон нутгийн арилжааны банкаар дамжуулан судлуулахаар шилжүүлсний дагуу Хаан банк судалж, 2020.01.04-нд Баянхонгор аймагт сангаас хуваарилагдсан эх үүсвэрээс 41.0 сая төгрөгийн зээлийг олгосон байна.


1.24. ХХААХҮС-ын 2019.05.14-ний өдрийн А/146 дугаар тушаалаар хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөлийг баталсан ба арилжааны банкаар дамжуулан олгох зээлийн хүүг 8 хувиас ихгүй байх, 5 хүртэл жилийн хугацаатай олгож, үндсэн зээлээс эхний 12 сарын хугацаанд чөлөөлөхөөр заасны дагуу Хаан банк 5.4%, Хас банк 5.6%, Төрийн банк 5.8%-ийн хүүтэй, 36-60 сарын хугацаатай олгож,

<sup>13</sup> Энэ журмын 12.3, 12.4-т заасан шийдвэрийг эрэмбэлсэн жагсаалтын хамт Аймгийн Засаг даргын тамгын газарт битүүмжлэн хүргүүлнэ.

<sup>14</sup> Засаг даргын Тамгын газар нь дэд хорооны шийдвэрийг хүлээн авсан даруйд аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулан банк болон санд хүргүүлнэ.

эхний 12 сарын хугацаанд үндсэн зээлээс чөлөөлсөн ба зарим зээлдэгч банктэй хугацаа тохирч заасан хугацаанаас бага хугацаатай зээл авсан байна.

1.25. Арилжааны банкаар дамжуулан 26 зээлдэгчид олгосон хөнгөлөлттэй зээлийг салбараар нь авч үзэхэд оёмол бүтээгдэхүүн болон сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл дийлэнх хувийг эзэлсэн байна.



1.26. ХХААХҮЯ-ны ЖДҮХС-аас батлагдаж, аймаг хуваарилагдсан 1000.0 сая төгрөгийн санхүүжүүлэх эх үүсвэрээс арилжааны 3 банкаар дамжуулан нийт 681.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, үлдэгдэл 319.0 сая төгрөгийг олгоогүй нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид зээл авч бизнесээ өргөжүүлэх боломжийг алдсан байна.

1.27. Төсөл ирүүлсэн иргэн, ААН арилжааны банкны шаардлагыг хангахгүйн улмаас дараагийн арилжааны банканд хандаж зээлийг судлуулсан боловч төслийн нийт санхүүжилтийн 30 хувийг өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлэх боломжгүй, арилжааны банкны зээлийн шаардлагад багадаа 6 сар үйл ажиллагаа эрхэлсэн зээлдэгчдэд зээл олгохоор заасан тул шинээр бизнес эрхлэгч нарт зээлийг олгох боломжгүй, орлогыг нотлох баримт дутагдалтай, барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй, банкны зээлийн хорооноос баталсан дүн ЖДҮХС-аас тогтоосон зээлийн доод хэмжээнээс бага дүнтэй батлагдсан зэрэг шалтгааны улмаас төсөл сонгон шалгаруулах Дэд хороогоор дэмжигдсэн 49 төслийн 48.9 хувь буюу 24 төсөлд зээл олгогдоогүй байна. Иймд цаашид сангаас ЖДҮ дэмжих зорилгоор орон нутагт хуваарилсан зээлийн эх үүсвэрийг бүрэн ашиглахын тулд арилжааны банкнаас зээл олгоход тавигдах шалгуур үзүүлэлтийг уян хатан тогтоох нөхцөл боломжийг судалж, арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг ХХААХҮЯ-д хүргүүлж ажиллах зөвлөмжийг ХХААГ-т хүргүүлэв.

1.28. Журмын 14.3.4<sup>15</sup>-т арилжааны банк төслийг 30 хоногт багтаан шийдвэрлэхээр заасан боловч тухайн зээлдэгч банкнаас шаардсан материалыг бүрдүүлэх, зээлийн судалгааг хийж, төв банк руу явуулж шийдвэр гаргуулсан зэрэг нь хугацаа шаардсаны улмаас 2019 оны 09 дүгээр сард 14, 10 дугаар сард

<sup>15</sup> Банк жагсаалтаар хүргүүлсэн төслийг хуанлийн 30 хоногт багтаан судалж, шаардлага хангасан төслийн шийдвэрийг банкны зээлийн хорооны шийдвэр, зээлийн гэрээ, барьцааны гэрээ болон нэхэмжлэлийн хамт баталгаажуулан санд хүргүүлнэ.

7, 11 дүгээр сард 2, 12 дугаар сард 2, 2020 оны 01 дүгээр сард 1 хүнд төслийн зээлийг олгосон байна. Иймд арилжааны банкнуудаар дамжуулан олгож байгаа ЖДҮХС-ийн зээлийг журамд заасан хугацаанд нь иргэдийг чирэгдүүлэхгүй, шуурхай олгож байх зөвлөмжийг Монгол банканд хүргүүлэв.

1.29. Арилжааны банкнууд төслийн зээлийг олгохдоо Монгол банкны мэдээллийн сангаас лавлагаа авч, журмын шаардлага хангасан иргэн, ААН-д хөнгөлөлттэй зээлийг олгосон боловч ХЭДС болон СХС-ийн зээл нь Монгол банкны мэдээллийн нэгдсэн санд ороогүйгээс бусад санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй иргэн, ААН-д ЖДҮХС-ийг зээлийг давхардуулан олгосон байна. "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК, сумын ЗДТГ, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраар дамжуулан иргэн, ААН-д олгож байгаа хөнгөлөлттэй зээлийн мэдээлэл Монгол банкны мэдээллийн санд ороогүй байгаа нь хугацаа хэтэрсэн зээлдэгчид давхардуулан зээл олгох, зээлдэгчийг өрийн дарамтад оруулах эрсдэлтэй байна. Иймд арилжааны банкнууд төрөөс олгож байгаа ХЭДС, СХС гэх мэт сангаас олгосон зээлийн лавлагааг холбогдох байгууллагуудаас авч, арилжааны зээлийг олгож байх зөвлөмжийг аймгийн Монгол банкны салбар, орон нутгийн төсвөөс олгож байгаа хөнгөлөлттэй зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүрэн оруулж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад хүргүүлэв.

#### ЖДҮХС-ААС ОЛГОСОН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙГ ЗАРИМ ЗЭЭЛДЭГЧ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН БАЙНА.

1.30. ЖДҮХС-аас зээл авсан 26 иргэн, аж ахуйн нэгжээс сумдад үйл ажиллагаа явуулж байгаа 5 зээлдэгчээс бусад 21 зээлдэгчийн үйл ажиллагаа, төсөлд заагдсан хөрөнгийг авсан эсэхийг газар дээр нь тулган шалгахад дараах 14 зээлдэгчид зээлийг зориулалтын дагуу ашиглаж, зээлийг үр дүнтэй зарцуулсан байна.

### "Хөвт харын нуруу" ХХК

#### Хүнсний нарийн ногоо тариалах-өвлийн хүлэмж барих

Хүнсний ногоо тариалах өвлийн хүлэмж барих 21.7 сая төгрөгийн төсөл ирүүлж, 20.0 сая төгрөгөөр дэмжигдэн зээл авсан Баянхонгор сумын 5-14-35 тоотод 20х6 харьцаатай өвлийн хүлэмж барьж, ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. Хашаандаа зуны 2 хүлэмж барьж өргөст хэмх, улаан лооль, гүзээлзгэнэ тарьж дунд захын "Богд хайрханы нуруу" дэлгүүртэй гэрээ байгуулан нийлүүлдэг байна. Одоогоор 4 хүнийг ажлын байраар ханган ажиллаж, НДШ төлдөггүй байна.



## Н.Энхтуяа

### Хүнсний ногоо тариалалт

"Урин хавар" хүнсний ногоо тариалалтын 31.5 сая төгрөгийн төсөл ирүүлж, 20.0 сая төгрөгөөр батлагдаж, хөнгөлөлттэй зээл авсан иргэн Н.Энхтуяа нь Баянхонгор сумын 7-17-8 тоотод хүнсний ногоо хадгалах гүний зоорио өргөтгөж, мөн байцааны агуулах барьсан, Өлзийт сумын нутаг Бумбатад 12х7 метрийн харьцаатай зоорийг барьж байна. Хоёр иргэнийг ажиллуулж, НДШ-ийг хувиараар төлдөг байна.



## "Баянцогт дэлгэрэх" ХХК

### Талх, нарийн боовны үйлдвэрлэл

Талх нарийн боовны үйлдвэрлэлийн цех өргөтгөхөөр 40.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, 20.0 сая төгрөгөөр батлагдаж, зээл авсан "Баянцогт дэлгэрэх" ХХК нь нарийн боовны үйлдвэрлэл эрхэлдэг ба зээлийн хөрөнгийг аймгийн Стандартчлал хэмжилзүйн ард байрлах өөрийн ажлын байрыг өргөтгөхөд зарцуулжээ. Одоогоор 7 нэр төрлийн нарийн боов үйлдвэрлэж, аймгийн зах зээлд нийлүүлж байгаа бөгөөд 4 хүнийг ажлын байраар хангаж байгаа ч НД-д хамруулаагүй байна.



## Д.Эрдэнэчимэг

### Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Аарц хатаах болон холих, савлах, бүрэх, ерөх бүх үйлдэл нэг дор тоног төхөөрөмж худалдан авахаар 25.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, 20.0 сая төгрөгөөр батлагдаж, хөнгөлөлттэй зээлийг авчээ. Д.Эрдэнэчимэг нь ЖИЖИ цөцгийтэй таргийг 4-5-18 тоотод өөрийн байрандаа үйлдвэрлэдэг байна. Төслийн хөрөнгөөр ааруул хатаагч, хөлдөөгч, сав баглаа боодол худалдан авч, 2 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байгаа ч НДШ-ийг төлдөггүй байна.



## Я. Чагнаадорж

### Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Иштэй тарган зайрмагны төсөл ирүүлж, 25.0 сая төгрөгөөр батлагдаж, хөнгөлөлттэй зээл авсан Я. Чагнаадорж нь "Мазаахай" зайрмагны үйлдвэрлэлээ Ажилсаг төвд явуулдаг бөгөөд төсөлд хамрагдсанаар түгээлтийн хөргүүртэй машин болон тоног төхөөрөмж худалдан авчээ.



## Э. Амгаланбаатар

### Тахианы аж ахуй эрхлэх

"Тахианы аж ахуй эрхлэх" 96.6 сая төгрөгийн төсөл ирүүлсэн 20.0 сая төгрөгөөр батлагдаж, хөнгөлөлттэй зээл авсан Э. Амгаланбаатар нь Өлзийт сумын нутаг дэвсгэрт 28x10 харьцаатай тахианы байр барьж ашиглалтад оруулсан ба 2500 тахиаг үржүүлж байна. Төсөл хэрэгжүүлснээр 2 ажлын байр шинээр бий болгож одоогоор 4 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байгаа боловч НД-д ажиллагсдыг хамруулаагүй байна.



## Ж. Сарнай

### Спорт хувцас үйлдвэрлэл

Спорт хувцас үйлдвэрлэлийн 20.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, дэмжигдэн 20.0 сая төгрөгийн зээл авсан Ж. Сарнай нь Баянхонгор сумын 1-р багийн 28 дугаар байрны 1-р давхарт өөрийн байрандаа спорт хувцасны үйлдвэрлэл явуулж байна. Төслийн хөрөнгөөр хувцсан дээр хээ гаргадаг өнгөт принтер авч үйл ажиллагаандаа хэвийн ашиглаж байна. Төсөлд хамрагдсанаар 3 ажлын байр нэмэгдэж, НДШ-ийг төлдөггүй байна.



## Н.Норов

### Оёдлын үйлдвэрлэл

"Новха" салонд тоног төхөөрөмж худалдан авах 40.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, 20.0 сая төгрөгөөр батлагдаж зээл авсан Н.Норов нь Политехник коллежийн хажуу талын байрны 1 өрөө байранд монгол хувцас, хуримын даашинз үйлдвэрлэл явуулж байна. Төслийн хөрөнгөөр 21.0 сая төгрөгийн өртөгтэй хатгамлын машин худалдан авсан ба 7 ажилтантай үүнээс төсөл хэрэгжүүлснээр шинээр 2 ажлын байр бий болгосон, НД-д хамрагдаагүй байна.



## С.Туяа

### Гутлын үйлдвэрлэл

Гутлын үйлдвэрлэл өргөжүүлэх 21.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, 20.0 сая төгрөгөөр батлагдан хөнгөлөлттэй зээл авсан иргэн С.Туяа нь Ажилсаг төвийн 217-3 тоотод үйл ажиллагаа явуулж байна. Төслийн зээлийг нийт 18 төрлийн багаж хэрэгсэл, клоток, тоног төхөөрөмж авахад зарцуулж, өвлийн гутал, хром хийж Баянхонгор аймаг болон Хөвсгөл, Архангай аймгуудад борлуулдаг бөгөөд нийт 5 хүнийг ажлын байраар хангадаг боловч НД-д хамруулаагүй байна.




## "Ингүүмэл баян" ХХК

### Гутлын үйлдвэрлэл

"Ингүүмэл баян" ХХК нь 55.0 сая төгрөгийн "Бат" гутлын үйлдвэрлэлийн төсөл ирүүлж, 55.0 сая төгрөгөөр батлагдаж хөнгөлөлттэй зээл авсан бөгөөд хуучнаар Урандөш буудлын нэг давхарт үйл ажиллагаагаа явуулж байна. Төслийн хөрөнгөөр ажлын байранд завсар хийж, тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгө авсан байна. Үйл ажиллагаа тасралтгүй явуулж байгаа нөхцөлд өдөрт 15 нэр төрлийн 10 хос гутал үйлдвэрлэдэг байна. Одоогоор 6 ажилтан ажиллуулж байгаагаас 4 хүний НДШ-ийг төлж байна.





## "Ширээ хайрхны нуруу" ХХК


Арьс, шир боловсруулах үйлдвэр

"Ширээ хайрхны нуруу" ХХК нь 95.8 сая төгрөгийн арьс шир боловсруулах үйлдвэрийн барилгын төсөл ирүүлж, 20.0 сая төгрөгөөр батлагдан хөнгөлөлттэй зээл авсан бөгөөд төслийн хөрөнгөөр Цэргийн ангийн урд үйлдвэрлэлийн байр барьж, үйл ажиллагаа явуулж байна. НДШ-ийг 4 ажилтнаар төлдөг байна.

## Б.Шижирбаатар

### Мод модон эдлэл, тавилгын үйлдвэрлэл


"Баянбүрд" төсөл бичиж 200.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, 70.0 сая төгрөгөөр батлагдаж, хөнгөлөлттэй зээл авсан Б.Шижирбаатар хуучнаар бөөний бараа баазын агуулахын баруун талд өөрийн хашаанд үйл ажиллагаа явуулж байна. Хөнгөлөлттэй зээлээр ажлын байрны өргөтгөл хийж, тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгө авахад зарцуулжээ. Одоогоор 9 хүн ажилладаг ба төсөл хэрэгжүүлснээр шинээр 5 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байгаа ч НД-д хамруулаагүй байна.



## "Хонгор мөнгөн үсэг" ХХК

### Мод, модон эдлэлийн үйлдвэрлэл

Үйлдвэрлэлээ өргөжүүлэхээр 40.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, 20.0 сая төгрөгөөр батлагдаж хөнгөлөлттэй зээл авсан "Хонгор мөнгөн үсэг" ХХК нь дунд захын ард байрлах өөрийн байрандаа сийлбэртэй гэрийн мод, аймгийн газрын зурагтай цаг, обжур, авдар зэргийг үйлдвэрлэдэг байна. Төслийн хөрөнгийг тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгө авахад зарцуулсан ба 1 байнгын, 1 түр ажлын байранд гэрээгээр ажилтан ажиллаж байна.



## Ц.Ганхуяг

### Бүх төрлийн вакуум цонхны үйлдвэрлэл

Энгийн болон хуванцар метал вакуум цонхны үйлдвэрлэл өргөтгөхөөр 68.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, 60.0 сая төгрөгөөр батлагдаж хөнгөлөлттэй зээл авсан Ц.Ганхуяг нь хуучнаар усны аж ахуйн хашаанд үйл ажиллагаагаа явуулж байна. Төслийн хөрөнгөөр 48.5 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, бараа материалд 15.0 сая төгрөг, суурилуулалтын зардалд 4.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Төсөл хэрэгжсэнээр 3 ажлын байр шинээр бий болгож, 7 ажилтан ажиллаж байна.



1.31. ЖДҮХС-аас зээл авсан 6 иргэн, 1 ААН төсөлд заагдсаны дагуу зээлийг зарцуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй зөрчил аудитаар илэрсэн тул дараах зээлдэгч нарт зөрчлийг арилгах 147.0 сая төгрөгийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлж, аймгийн ХХААГ-т хариуцуулав.

#### **Аудитын илрүүлэлт**

1. Төрийн банкнаас хөргүүртэй зоорь барих 20.0 сая төгрөгийн төсөл авсан иргэн А.Мягмар нь төслийг зориулалтын дагуу зарцуулаагүй;
2. Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч "Бүрэндүүрэн ариун заяат" ХХК нь Хас банкнаас авсан 20.0 сая төгрөгийн зээлээр ажлын байрны өргөтгөлийг барьсан боловч төсөлд тусгагдсан хавтгайн сийлбэрийн машиныг худалдан аваагүй байсныг аудитын явцад зөрчлийг арилгуулав.
3. Эсгий, эсгийн үйлдвэрлэл эрхэлдэг Д.Амар-Амгалан нь Төрийн банкнаас 20.0 сая төгрөгийн төсөл авч, ноос худалдан авсан гэх боловч төслийн зээл авснаас хойш үйл ажиллагаа явуулаагүй;
4. Билэг бууз үйлдвэрлэл эрхлэгч Н.Мэндбаяр Хаан банкнаас 20.0 сая төгрөгийн зээл авч шаардлагатай тоног төхөөрөмж авахаар төсөлд заагдсан боловч зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн хөрөнгөөр суудлын автомашин худалдан авсан;
5. "Тугалхан" чипсэн ааруулын үйлдвэрлэл эрхлэгч Ж.Энхсайхан нь Хаан банкнаас авсан 20.0 сая төгрөгөөр төсөлд тусгагдсан ажлын байрыг бариагүй;
6. Спорт хувцасны үйлдвэрлэл эрхлэгч В.Орхонтуул нь 30.0 сая төгрөгийн төсөл бичиж, үүнээс 26.0 сая төгрөгийн 2 толгойтой лого хатгамлын машин авахаар заасан боловч Хаан банкнаас олгосон 20.0 сая төгрөгийн зээлээр хатгамлын машин аваагүй, зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.
7. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч иргэн Б.Жавзандулам нь ЖДҮХС-аас 71.4 сая төгрөгийн зээл хүсэж, тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулах төсөл ирүүлж, ЖДҮХС-аас 41.0 сая төгрөгийг баталсан ба арилжааны банктай байгуулсан гэрээнд ажлын байр барих зориулалтаар зээлийг ашиглахаар заасан боловч зээлдэгч зээлийг эргэлтийн хөрөнгө худалдан авахад зарцуулж тус тус зориулалт бусаар ашигласан байна.

1.32. Дэд хороо төсөл ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн анх хүссэн зээлийг бууруулж баталснаас санхүүжилт дутагдаж төсөлд заагдсан зориулалтын дагуу

зээлийг бүрэн ашиглах боломжгүй болсон гэсэн тайлбарыг ихэнх зээлдэгч өгсөн болно.

1.33. Иймд төсөл сонгон шалгаруулах дэд хороо болон арилжааны банкнаас хөнгөлөлттэй зээлийн зарцуулалтыг тодорхой болгож, гэрээний хавсралтаар баталж өгөх шаардлагатай тул холбогдох албан тушаалтнуудад энэ талаар зөвлөмж хүргүүлэв.

1.34. Арилжааны банк зээлдэгчтэй байгуулсан гэрээнд зээлийн зориулалтыг андуурч бичсэнийг аудитын явцад холбогдох зээлийн мэргэжилтнүүдэд танилцуулсан ба цаашид зээлийн зориулалтыг гэрээнд үнэн зөв тусгаж ажиллах зөвлөмжийг Монгол банкны салбарт хүргүүлэв.

1.35. ЖДҮХС-аас Баянхонгор аймагт хуваарилагдсан санхүүжилтийг олгосон зээлтэй харьцуулсан судалгааг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзэхэд өмнөх онуудтай харьцуулахад 2019 онд эх үүсвэрийн 68.1 хувийг олгосон байна.



1.36. Энэ нь жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох журмын шаардлагыг хангасан ЖДҮХС-аас зээл авсан иргэд, аж ахуйн нэгжүүд илүү олон бий болж, аймаг орон нутагт ажлын байрыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж байгаа ач холбогдолтой байна.

1.37. Аудитын явцад аймгийн ХХААГ-аас авсан судалгаанаас харахад ЖДҮХС-аас хөнгөлөлттэй зээл авсан 2 аж ахуйн нэгж зээлийг зориулалт бусаар зарцуулсны улмаас 2017 онд Төрийн аудитын байгууллагаас төлбөрийн акт тогтоож, барагдуулсан байна.

1.38. ЖДҮХС-аас зээл авсан иргэн, ААН зээлийг хугацаанд нь бүрэн төлж барагдуулсан байна.

**ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР ШИНЭЭР БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ БИЙ БОЛСОН Ч АЖЛЫН БАЙРЫГ ТӨСӨЛД ЗААГДСАН ХЭМЖЭЭНД НЭМЭГДҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

Дүрслэл 3. Шинээр нэмэгдсэн ажлын байрны тоо /салбараар/



ЖДҮХС-аас олгосон хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 26 иргэн, аж ахуйн нэгжийн ажлын байрыг аудитаар тулган баталгаажуулахад хадгалсан болон шинээр бий болсон ажлын байрыг нийгмийн даатгалд мэдээлж,

баталгаажуулахгүй байгаа нь тухайн зээлдэгчийн ажиллагсдын бодит тоог нотлох боломжгүй байгаа бөгөөд зээлдэгч нар 82 ажлын байр хадгалж, шинээр 44 ажлын байрыг бий болгосон гэсэн мэдээллийг өгсөн болно.


Шинээр нэмэгдсэн ажлын байрыг салбараар авч үзвэл оёдлын үйлдвэрлэлийн салбарт 12 ажлын байр, мод, модон эдлэл, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарт тус бүр 5 ажлын байр нэмэгдсэн үзүүлэлт гарч байна.

1.39 Гэвч аймгийн ХХААГ-аас ХХААХҮЯ-д гаргаж явуулсан мэдээнд 26 иргэн, аж ахуйн нэгжид 73 ажлын байр хадгалагдаж, 68 ажлын байр шинээр нэмэгдсэн гэж тайлагнасан нь арилжааны банкны гаргасан судалгаанаас зөрүүтэй байна.

1.40. Иргэн, ААН-ийн ирүүлсэн зарим төсөл дээр хадгалсан болон шинээр нэмэгдүүлэх ажлын байрны тоог бичээгүй, зарим төсөл дээр төслийн зорилт дээр болон тооцоололд өөр өөр тоог бичсэн, хөнгөлөлттэй зээлд хамрагдахын тулд төсөлд ажлын байрны тоог тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр хэт өндрөөр төсөвлөсөн ба төсөлд бичигдсэн ажлын байрны тоог нэгтгэж дүгнэхэд 64 ажлын байрыг хадгалж, шинээр 98 ажлын байрыг бий болгоно гэжээ.



1.41. Дээрх хадгалсан болон шинээр нэмэгдсэн 126 ажилтны НДШ-ийн төлөлтийг тулган шалгахад 85% буюу 104 ажилтны НДШ-ийг төлөөгүй, 15 хувь буюу 22 ажилтны НДШ-ийг төлсөн ба үүний 10 хувь нь сайн дурын даатгалд хамрагдаж, үлдэх 5 хувь нь аж ахуйн нэгжээс НДШ-ийг төлсөн байна.



1.42. Төсөлд заагдсан ажлын байрыг нэмж, ажиллагсдын НДШ-ийг төлж байгаа эсэхэд тавих хяналт сул байгаагаас ажлын байрыг нэмэгдүүлэх зээлийн үндсэн зорилт хангагдахгүй байгаад цаашид анхаарч, ЖДҮ эрхлэгчдийг санхүүгийн анхан шатны бүртгэл хэрхэн хөтлөх, ажилтан авч ажиллуулж байгаа нөхцөлд ямар үүрэг хариуцлага ногдох талаарх сургалтыг явуулж ажиллах зөвлөмжийг аймгийн ХХААГ-ын даргад хүргүүлээ.

1.43. ЖДҮХС-аас авсан зээлийг төсөлд заагдсан зориулалтаар зарцуулж, шинээр импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж, өөрийн болон бусад аймгийн зах зээлд нийлүүлсэн давуу талтай байна. Тухайлбал:

Арьс ширний үйлдвэрлэлийн салбар нь хөнгөн үйлдвэрийн томоохон салбарын бөгөөд манай аймгийн хувьд “Ширээ хайрхны нуруу” ХХК нь арьс ширийг боловсруулж, бүх төрлийн автомашины суудлын бүрээс, нэхий дээл зэргийг үйлдвэрлэж аймгийн хэрэглэгчдэд борлуулж байна.

Мөн энэ салбарт “Ингүүмэл баян” ХХК нь боловсруулсан арьсаар бүх төрлийн гутал хийж аймгийн хэрэглэгчдийг хангаж, мөн “Баянхонгор Эрчим хүч” ЦТ ХХК-ийн ажилчдын нормын гутлыг хийж нийлүүлсэн байна.

Ажилсаг төв дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн С.Туяа нь боловсруулсан арьсаар бүх төрлийн гутал, хром хийж Баянхонгор аймаг болон Хөвсгөл, Архангай зэрэг аймгийн хэрэглэгчдэд нийлүүлж байгаа томоохон давуу талтай байна.

Мод модон эдлэлийн үйлдвэрийн салбарт иргэн Б.Шижирбаатар нь гэрийн бүхий л төрлийн тавилга үйлдвэрлэж, дотоодын зах зээлд нийлүүлдэг, “Хонгор мөнгөн үсэг” ХХК нь иж бүрэн сийлбэртэй гэр, гэрлийн овжур, авдар зэрэг модон эдлэл үйлдвэрлэж байна.

Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбар нь ноос, ноолуур, арьс шир түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгон нэмүү өртөг хамгийн их шингээдэг үйлдвэрлэлийн салбар юм. Оёдлын салбарт иргэн Ж.Сарнай нь “Monline” брендийн биеийн тамирын хувцсыг хээ оруулан үйлдвэрлэж байгаа бол “Новха” салон нь үндэсний хэв маягт нийцүүлсэн хуримын хувцас хийж, 1 толгойтой лого хатгамлын машинаар бүх төрлийн логог гаргаж байгаа нь импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа жишээ юм.

**ОРОН НУТГИЙН ОРЛОГООС ХАС БАНКАНД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАРЬЦАА ДАНСАНД БАЙРШУУЛСАН 75.0 САЯ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТЭЭС СҮҮЛИЙН ЖИЛҮҮДЭД ЗЭЭЛ ОЛГООГҮЙН УЛМААС ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ БУЦААН ТАТЖЭЭ.**

1.44. Үйлдвэр худалдааны сайд, аймгийн Засаг дарга, Хас банкны гүйцэтгэх захирал нар 2007.05.28-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулж, орон нутгийн орлогоос нийт 75.0 сая төгрөгийг Хас банкны Тусгай зориулалтын санд байршуулж, аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн тайланд авлагаар бүртгэсэн байна.

Хүснэгт 6. Хас банкны дансанд байршуулсан санхүүжилт /сая төг/

Санхүүжилтийн төрөл	2007 он	2008 он	2009 он	Дүн
Баянхонгор сангаас	10.0	-	-	10.0
Орон нутгийн орлогоос	15.0	30.0	20.0	65.0
Дүн	25.0	30.0	20.0	75.0

Эх сурвалж: 2017 оны ЖДҮДС-ийн зээлийн хуваарилалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

1.45. Орон нутгаас олгосон санхүүжилтээр аймгийн Засаг даргын захирамжаар иргэн, ААН-д ЖДҮ хөгжүүлэх зориулалтаар жилийн 9 хувийн хүүтэй, 36 сарын хугацаатай хөнгөлөлттэй зээлийг олгож байсан ба хамгийн сүүлд 2017 онд Хас банк 2 иргэнд 13.0 сая төгрөгийн зээлийг олгож, тус зээлдэгч нар 2020 оны 3,5 дугаар сард зээлийг төлж дуусгасан ба 2018-2019 онд тус дансанд байршуулсан санхүүжилтээс зээл олгоогүй байна.

1.46. Аймгийн Засаг даргын 2020.05.04-ны 1а/284 дүгээр захирамжаар тусгай зориулалтын санд байршсан дээрх 75.0 сая төгрөгийг бодогдсон хүүгийн хамт “Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн дансанд шилжүүлэх шийдвэр гарсны дагуу 2020.05.08-ны өдөр Хас банкнаас 2.8 сая төгрөгийн хүү, нийт 77.8 сая төгрөгийг тус компанийн дансанд шилжүүлж, өмнөх аудитын зөвлөмжийн үр өгөөж гарсан байна.

1.47. “Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК дээрх санхүүжилтийг НББ-д тусгаж, ЖДҮ-ийн зээл хүссэн иргэн, ААН-д зээл олгох аймгийн Засаг даргын 2020.06.10-ны өдрийн А/391 дүгээр захирамжийн дагуу хөнгөлөлттэй зээлийг тус эх үүсвэрээс олгож эхэлсэн байна.

1.48. Хас банканд байршуулсан хөрөнгөөс олгосон зээлүүдийг бүрэн төлж барагдуулсан байгаа ба аймгийн ХХААГ-аас авсан судалгаанаас үзэхэд тус хөрөнгөөс олгосон зээлийн зарцуулалтад аймгийн Төрийн аудитын байгууллага 2013, 2017 онд гүйцэтгэлийн аудит хийж, зээлийг зориулалт бусаар ашигласан 2 аж ахуйн нэгжид 68.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, бүрэн барагдуулсан байна.

### **БҮЛЭГ 3. ЖДҮХС-ААС ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗАРЦУУЛАЛТАД АЙМГИЙН ХХААГ ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.**

#### **АЙМГИЙН ХХААГ-ЫН ЖДХҮАҮ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.**

1.49. “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээлийн хуваарилалт, үр дүн”-д 2017 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн ИТХ-ын даргад 1, аймгийн Засаг даргад 3, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, мэргэжилтэнд 2 заалт бүхий зөвлөмж өгч, хэрэгжилтийг албан бичгээр ирүүлжээ.

1.50. Ирүүлсэн албан бичигт үндэслэн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгахад аймгийн ХХААГ-ын ЖДХҮАҮ хариуцсан мэргэжилтэн ХХААХҮЯ-д хүргүүлсэн мэдээ тайланг бодит тоонд үндэслэн тайлагнаагүй, өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.51. Аймгийн ХХААГ-ын ЖДХҮАҮ хариуцсан мэргэжилтэн 2019 онд ЖДҮХС-аас олгосон зээлд хамрагдсан иргэн, ААН-ийн зээл ашиглалт, ажлын байр нэмэгдүүлсэн байдалд хяналт тавьж ажиллаагүй, ХХААХҮЯ-д хүргүүлсэн тайланг зөрүүтэй гаргасан, шалгараагүй буцаагдсан төслийн шалтгааныг журмын дагуу дэлгэрэнгүй бүртгэж баталгаажуулаагүй, дэд хорооны хурлын тэмдэглэлийг дэлгэрэнгүй хөтлөөгүй, бусад сангаас зээл авсан иргэн, ААН-ын судалгааг авч сонгон шалгаруулалтад ашиглаагүй зэргээр ажилд хариуцлагагүй

хандаж журмын 1.4.2<sup>16</sup>, 7.2<sup>17</sup>, 9.5<sup>18</sup>-д заасныг зөрчсөн тул тус мэргэжилтэнд хариуцлага тооцож арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн ХХААГ-ын даргад хүргүүлэв.

ТӨСӨЛД ХАМРАГДСАН ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИД АРИЛЖААНЫ БАНК ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАСАН БОЛОВЧ АЙМГИЙН ХХААГ-ААС ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

1.52. Хаан банкаар дамжуулан ЖДҮХС-аас зээл авсан 21 зээлдэгчийн үйл ажиллагаанд хариуцсан зээлийн мэргэжилтэн нар 2019 оны 11 дүгээр сард хяналт тавьсан, мөн Хаан банкны төв салбараас ЖДХҮАҮ хариуцсан албан тушаалтан 2020 оны 03 дугаар сард ЖДҮХС-аас зээл авсан зээлдэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хяналтын хуудас хөтөлсөн байна.

1.53. Төрийн банк хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 2 зээлдэгчийн үйл ажиллагаанд 2 удаа хяналт тавьж ажилласан байна.

1.54. Харин Хас банк зээлдэгчийн үйл ажиллагаа доголдох, зээлийн төлөлт хугацаа хэтрэх тохиолдолд хяналт хийдэг ба ЖДҮХС-аас зээл авсан 3 зээлдэгчийн хувьд эргэн төлөлт хугацаандаа төлөгдөж байгаа тул зээлдэгчдийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна.

1.55. Аймгийн ХХААГ-аас зээлдэгч нарын үйл ажиллагаа, зээлийн зарцуулалт, ажлын байр нэмэгдүүлсэн байдалд хяналт тавьж ажиллаагүй байна. Иймд ЖДҮХС-аас олгосон зээлийн ашиглалт, ажлын байр нэмэгдүүлсэн байдалд арилжааны банкт хамтран хяналт тавьж, бодит тоонд үндэслэн мэдээ тайлан гаргаж, холбогдох газруудад хүргүүлж байх зөвлөмжийг аймгийн ХХААГ-т хүргүүлэв.

Аудитаар нийт 181.3 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 34.3 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 147.0 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах 10 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

<sup>16</sup> Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.6, 5.4.8, 5.4.14, 5.4.18-д заасан сангуудад болон сум хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй.

<sup>17</sup> Дэд хороо нь аймгийн мэргэжилтний судалсан төслийг хуралдаанаар хэлэлцэх, сонгон шалгаруулах, холбогдох хууль, дүрэм, журам, зааврын дагуу шийдвэр гаргах эрх

<sup>18</sup> Сан болон аймгийн мэргэжилтэн нь өөрийн судалсан төслийн үнэн зөвийг бүрэн хариуцна

**БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ**

262.



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
МОНГОЛБАНКНЫ САЛБАР**  
64101 Баянхонгор аймаг, Баянхонгор сум  
Номгон бар E-mail: mb\_36@mongolbank.mn  
Утас,Факс 7044 2156

2020.06.29 № А/43  
танай 2020.06.29 -ны № 1/465 -т

Г БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХБАТ ТАНАА

“Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Монголбанкны салбарын зүгээс тайланд тусгагдсан 2 зөвлөмжийг цаашид хэрэгжүүлэн ажиллах талаар арилжааны банкуудад албан бичиг хүргүүлэн ажиллах боломжтой болно.

Санал:

1.Аймгийн хэмжээний төслийн зээл, бусад сангууд, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорациас олгогдсон бүх төсөл, сангийн санхүүжилттэй зээлийн мэдээллийг Төрийн сангийн “Зээлийн мэдээллийн сан”-д нэвтрэх эрх бүхий ажилтнаар дамжуулан нэгдсэн баазад оруулах ажлыг Санхүү төрийн сангийн хэлтэсийн даргад хариуцуулан зөвлөмж хэсэгт оруулах саналтай байна.

Саналыг хүлээн авч, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад зөвлөмж хүргүүлэв.

Хүндэтгэсэн:

ЗАХИРАЛ

*Г.Олонбаяр*  
Г.ОЛОНБАЯР  
2520250

E:\backup20190815\Documents\2019\alban toot.doc

Аймгийн ХХААГ-аас аудиттай тайлантай холбоотой санал ирүүлээгүй болно.



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг  
Баянхонгор сум, Рашаант баг  
Утас 7044 2478


2020 06 29 № 3/101  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г **БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ** Г

Танай газраас “Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцав.

Цаашид дэд хороодын гишүүдэд мэдээлэл өгч, тайланд дурдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллах тул, төсөлд саналгүй болно.

Хавсралт 28 хуудастай.

ДАРГА  Ж.БАТТӨР

*Б.Дамшар*  
Тайланг хөрсгөрөх.  
*2020.06.29*

2520304

2020он А5

**АУДИТЫН ДҮГНЭЛТ**

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. ЖДҮХС-аас 2019 онд орон нутагт 1000.0 сая төгрөгийн эх үүсвэрийг баталж хуваарилсанаас 26 зээлдэгчид 681.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, арилжааны банкны зээлийн шалгуур үзүүлэлтийг хангаагүйгээс 319.0 сая төгрөгийн эрхийг ашиглаж чадаагүй байна.
2. “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК, сумын ЗДТГ, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраар дамжуулан иргэн, ААН-д олгож байгаа хөнгөлөлттэй зээлийн мэдээлэл Монгол банкны мэдээллийн санд ороогүй байгаа нь хугацаа хэтэрсэн зээлдэгчид давхардуулан зээл олгох, зээлдэгчийг өрийн дарамтад оруулах эрсдэлийг бий болгож байна.
3. “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 1.4.2 дахь заалтыг зөрчиж, төсөл сонгон шалгаруулах дэд хороо бусад санд 34.3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 2 иргэн, 2 ААН-д ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлийг давхардуулан олгожээ.
4. Дэд хороо төсөл ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн анх хүссэн зээлийг бууруулж баталснаас төсөлд заагдсан зориулалтаар зээлийг ашиглахад санхүүжилтийн эх үүсвэр дутагдаж, хэрэгжүүлэх боломжгүй болж байгаа бөгөөд дэд хороогоор дэмжигдсэн төслийн санхүүжилтийг хэрхэн зарцуулах, хэдэн ажлын байр нэмэгдүүлэхийг тодорхой заагаагүй байна.
5. Арилжааны банк журмын 14.3.4-т заасан хугацааг баримталж 30 хоногийн дотор зээлийг олгоогүй, зээлдэгчтэй гэрээ байгуулахдаа төсөлд тусгагдаж батлагдсан зээлийн зориулалтыг гэрээнд тодорхой, үнэн зөв тусгаагүй байна.
6. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан зарим зээлдэгч төсөлд заагдсан үйл ажиллагаа эрхлээгүй, зээлийг зориулалт бусаар зарцуулсан ба төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж хөнгөлөлттэй зээлийн зарцуулалтыг анхан шатны баримтаар баталгаажуулаагүйгээс зээлийг хэрхэн зарцуулсныг нотлох боломжгүй байна.
7. ЖДҮХС-аас санхүүжүүлсэн төсөл хэрэгжсэнээр импортыг орлох бүтээгдэхүүн бий болсон ч аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2019 онд сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 26 зээлдэгчийн зээлийн зарцуулалт, ажлын байр нэмэгдүүлж, нийгмийн даатгалд хамруулсан байдалд хяналт тавьж ажиллаагүй, ХХААХҮЯ-д хүргүүлсэн мэдээнд хадгалсан болон шинээр нэмэгдсэн ажлын байрны тоог бодит байдлаас зөрүүтэй тайлагнасан байна.
8. Аймгийн ХХААГ-ын ЖДХҮАҮ хариуцсан мэргэжилтэн холбогдох журмыг мөрдөж ажиллаагүйгээс хугацаа хэтэрсэн зээлтэй иргэн, ААН-д сангийн зээлийг давхардуулан олгосон, ажилдаа хариуцлагагүй хандсаны улмаас өмнөх аудитаар илэрсэн алдаа зөрчил бүрэн арилаагүй байна.

ДАРГА

Б.МӨНХБАТ

6417143544  
БНОА0067 0007423

**АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорх албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

**Нэг. Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Байгалмаа танаа**

1. Сумдын Засаг даргын захирамжаар олгож буй сум хөгжүүлэх сан, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраар дамжуулан олгож байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-аар олгож буй ЖДҮ хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүрэн оруулах.

**Хоёр. Төсөл сонгон шалгаруулах дэд хорооны дарга бөгөөд аймгийн Засаг даргын орлогч дарга Б.Батсуурь танаа**

1. “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”, ХХААХҮЯ-аас ирүүлсэн чиглэлийг баримтлан шаардлагад нийцсэн төслийг сонгон шалгаруулж, шалгараагүй төслийн буцаасан шалтгааныг журмын 1.4-т заасны дагуу дэлгэрэнгүй бүртгэж, баримтжуулж байх.
2. ЖДҮХС-ийн эх үүсвэрээр олгохоор батлагдсан хөнгөлөлттэй зээлийг бууруулж баталсан тохиолдолд зээлийн зориулалт, нэмэгдүүлэх ажлын байрыг зээлдэгчтэй зөвшилцөн тодорхой болгож, төслийн хавсралт болгон нэмэлтээр баталж байх.

**Гурав. Баянхонгор аймаг дахь Монгол банкны салбарын захирал****Г.Олонбаяр танаа**

1. Төрөөс олгож байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн лавлагааг холбогдох байгууллагуудаас авч, арилжааны зээлийг олгож байх арга хэмжээг авч ажиллах.
2. Дэд хорооноос батлагдсан зээлийг журамд заасны дагуу 30 хоногт багтаан олгож, төслийн зориулалтыг зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээнд үнэн зөв, тодорхой тусгаж, зээлийг зориулалт бусаар ашигласан зээлдэгч нарт холбогдох арга хэмжээг тухай бүр нь авч, хэрэгжилтийг тооцож байх зөвлөмжийг арилжааны банкнуудад хүргүүлж ажиллах.

**Дөрөв. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Баттөр танаа**

1. ЖДҮХС-аас олгож байгаа хөнгөлөлттэй зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаад хяналт тавьж, ажлаа сайжруулах.
2. Сангаас ЖДҮ дэмжих зорилгоор орон нутагт хуваарилсан зээлийн эх үүсвэрийг бүрэн ашиглахын тулд арилжааны банкт байгуулах гэрээнд зээл олгоход тавигдах шалгуур үзүүлэлтийг уян хатан тогтоох нөхцөл боломжийг судалж, арга хэмжээ авч ажиллах саналыг ХХААХҮЯ-д хүргүүлж ажиллах
3. Зээлдэгчийн хадгалсан болон шинээр бий болсон ажлын байрыг төсөлд бичигдсэн тоотой харьцуулан дүгнэж, нийгмийн даатгалд хамрагдсан байдалд хяналт тавьж, ХХААХҮЯ-д төсөл хэрэгжүүлсний үр дүнд бий болсон ажлын байрны тоог үнэн зөв тайлагнаж байх.

4. Төслийн зээлийг санхүүгийн анхан шатны баримтаар баталгаажуулж зарцуулах, төсөлд заагдсан тоног төхөөрөмж, бараа материалын үнийг дансаар дамжуулан шилжүүлэх, зээлийг зориулалт бусаар зарцуулсан тохиолдолд ямар үүрэг хариуцлага ногдох талаарх сургалтыг явуулж, зээлдэгч нарыг арга зүйгээр хангаж дэмжиж ажиллах.
5. Холбогдох журмыг мөрдөж ажиллаагүй, ажилдаа хариуцлагагүй хандсан албан тушаалтанд хариуцлага тооцох арга хэмжээ авч ажиллах

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хугацаанд нь барагдуулж, өгсөн зөвлөмжийн мөрөөр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг нотлох баримтын хамт 2020 оны 11 дүгээр сарын 09-ны дотор албан бичгээр хариу ирүүлнэ үү.

ДАРГА  Б.МӨНХБАТ

6417143544  
БЧОА0067 9007423